

БАРУУН-УРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН 2021 ОНЫ 11 ДҮГЭЭР САРД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр

Баруун-Урт сум

НЭГ.ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Тус Тамгын газар 11 дүгээр сард:

- Явсан бичиг 61
- Ирсэн бичиг 41
 - Хариутай бичиг 26
 - Хугацаандаа явсан 10
 - Хугацаа болоогүй 9
 - Хугацаа хэтэрсэн 7 /кейс/

Ирсэн бичгийг цаг тухай бүрт удирдлагад танилцуулан, холбогдох мэргэжилтэн, албан хаагчид хяналтын хуудас хөтлөн хүлээлгэж хариутай бичгүүдийг хугацаанд нь шийдвэрлэж ажилласан.

Өдөр тутмын үйл ажиллагаандаа архив, албан хэргийн хөтлөлтийн стандарт, журмыг мөрдөн ажилласан.

Тайлант сарын байдлаар Засаг даргын “А” захирамж- 24, Б захирамж-0, Тамгын газрын даргын “Б” тушаал-9, А тушаал-0 тус тус гарсан байна.

5 иргэнд архивын лавлагаа өгсөн байна.

Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, тус Тамгын газрын албан хаагчдын ажлын бүтээмжийг дээшлүүлэх, чадамжийг сайжруулахын тулд Чанарын удирдлагын тогтолцоо 9001 стандартыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэхэд гол анхаарал хандуулан ажилласан. Стандартын 4 дүгээр үе шат болох Хэрэгжүүлэлт хэсгээр байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлийг тодорхойлж SWOT шинжилгээг байгууллага дээрээ хийж гүйцэтгээд байна. Төслийн багт 18 албан хаагч хамрагдаж байна.

ХОЁР: БАЙГАЛЬ, ОРЧИН, ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЭЦ, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

- 2021 оны төлөвлөгөөний дагуу хийгдэх, дэд бүтэц, газар зохион байгуулалтын ажлууд хийгдэж байгаа бөгөөд Захирагчийн албаны зүгээс дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.
- 2022 оны газар зохион байгуулалтын төслийг ГХБХБГазраас ажлын хэсэг томилогдон хэлэлцүүлгийн ажлыг 11-р сарын 20-ны өдөр хийсэн. Тус ажлын хэсэгт ДБЭХС ТӨХК- Сүхбаатар салбар, Дөрвөлж ХК, МХС-ТӨХК, МХГ, ОБГ, БОАЖГ тус тус оролцож хэлэлцсэн.
- Шинэ суурьшлын бүс Эко хорооллын 19 айлын дэд бүтэц, шугам сүлжээний ажлыг Хүрд ХХК гүйцэтгэсэн. Тус ажлыг сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг томилогдон үүрэг чиглэлийг өгч хүлээн авсан.
- 1-р баг Мандал хорооллын 109-р байрны гадна пасадын ажлыг 30,0 сая. төгрөгийг төсөвт өртөгөөр 338-р анги гүйцэтгэж ажлыг хүлээлгэн өгсөн.
- 1-р баг Мандал хорооллын 106-р байрны айл өрхүүдийг газар чөлөөлөх ажлын хэсэг байгуулж 15 иргэдтэй гэрээ байгуулан хувийн хэргийг бүрдүүлж

аймгийн төрийн сангийн хэлтэст хүргүүлэн нөхөн олговор олгох 88,0 сая.төгрөгийг олгосон байна.

- 7-р 27а,б, 36 а,б байрны дээвэр засварын ажлыг Хайлааст гарам ХХК хийж гүйцэтгэж ажлыг сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг томилогдон үүрэг чиглэлийг өгч хүлээн авсан.
- 4-р багийн хашааг шинэчлэх төсөлд тендер зарлагдаж Хайлааст гарам ХХК шалгарсан ба нийт 45 хашааны хаалга угсрах ажил хийгдэж дуусаад байна.
- 2-р багийн саруул хотхоны орчныг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор 5,0 сая.төгрөгийн өртөгөөр Талын технологи ХХК хийж гүйцэтгэж хүлээлгэн өгсөн.
- Багуудын нийтийн эзэмшлийн гудамж талбайг тэгшлэх ажлыг 6,1 сая.төгрөгийн өртөгөөр Монгол зам групп ХХК хийж гүйцэтгэсэн.
- Гэр хороололын гудамж талбайд 84 ш цамхагт гэрэлтүүлгийг " Уртын гэгээ" ОНӨААТҮГ хийж гүйцэтгэсэн ба тус ажлыг хүлээн авсан.
- ОНХС-н хөрөнгө оруулалтаар хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл болон баримт бичгийн бүрдэлтийг хийж байна.
- "Зөв хэвшил –Зөв амьдрал" аяны хүрээнд Сүхбаатар аймгийн АА нийгэмлэгийн үйл ажиллагааг орон нутгийн BBS телевизтэй хамтран суртачиллах, мөн багийн ажлын албатай ААНийгэмлэгийн үйл ажиллагааг сурталчиллах ажлыг хийсэн.
- 2021 оны жилийн эцсийн тайлан мэдээг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.
- ISO 9001:2015 стандартыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд ажлын хэсэгт мэргэжилтэнүүд өөрийн хариуцсан ажлын дагуу холбогдох заалтуудыг гаргасан байна.
- Баруун-Урт сумын хогийн нэгдсэн цэгийг шинээр байгуулах ажилд хяналт тавьж ажилласан. Төслийн хүрээнд 1 га газрыг тохижуулах, хашаажуулах ажил хийгдэж байна. явц 60 хувьтай байна.
- Аймгийн ИТХ-р батлагдах "Энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, булшлах журам"-ын хэлэлцүүлгийг Аймгийн ЗДТГ, МХГ, БОАЖГ, БУ сумын ЗДТГ, Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ, Төслийн зөвлөх оролцож хэлэлцсэн.
- Гамшгаас хамгаалах команд штабын сургалтыг зохион байгуулж нийт 4 үе шаттай сургалт зохион байгуулагдсан. Тус арга хэмжээнд Сумын онцгой комиссын 45, ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн 66 хүний бүрэлдэхүүн оролцсон.
- Гамшгийн эрсдлийн ерөнхий үнэлгээг сумын хэмжээд 7 төрөлд анхан шатны үнэлгээ хийгдсэн.
- Хотын төвөөс мал гаргах ажилд хяналт тавьж байгаа ба 8-р багийн иргэн Н, 1-р багийн иргэн А нарын 2 удаа хашигдсан 30 тооны малын эздүүдэд захиргааны арга хэмжээ авч ажилласан.
- 5,9-р багт баригдах усан сангийн тендер зарлагдаж байна.

ГУРАВ: ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

- Хүнсний дэлгүүрүүдэд "Тамхины хяналтын тухай хууль", тогтоомжийн хэрэгжилтийн биелэлтийг хангах ажлын хүрээнд тамхины зөвшөөрөл хүссэн

18 аж ахуйн нэгжүүдэд хэмжилт хийн ажилласан. Уг ажлыг Цагдаагийн газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Баруун-Урт сумын худалдаа эрхлэгчдийн ТББ, Аж ахуйн нэгжүүдийн захирал нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг гарч ажилласан. Хэмжилтийг сургууль болон сурагчийн дотуур байрны ашигтай цэгээс аж ахуйн нэгжийн хаалга хүртэл хийж, хуулийн дагуу хэмжилт хүрсэн 15 аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгосон.

- Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн 10 аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгосон.
- Ковид-19 цар тахалтай холбогдуулан сумын хэмжээнд томоохон үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдээс нөөцийн мэдээг 11 аж ахуйн нэгжээс 12 төрлөөр, махны мэдээг 6 аж ахуйн нэгжээс 5 төрлөөр, үнийн мэдээг 11 аж ахуйн нэгжээс авч нэгтгэн, 7 хоног бүрийн 1 дэх өдөр хугацаанд нь холбогдох газарт мэдээлэн ажилласан.
- Аж үйлдвэрийн мэдээг сумын хувиараа үйлдвэрлэл эрхэлдэг иргэдээс хүнс, оёдол, модон эдлэл, блок зэрэг чиглэл, чиглэлээр сарын үйлдвэрлэлийн хэмжээг нэгтгэж Статистикийн хэлтэст мэдээлсэн.
- ХХААХҮ-ийн сайдын А/319 дугаар тушаалаар нийслэлийн хүн амын хүнсний хэрэгцээг хангах зорилгоор “Өвлийн идэш арга хэмжээнд оролцох тухай” албан бичгийн дагуу Баруун-Урт сумын мах боловсруулах үйлдвэрүүдтэй биечилж уулзан, үйл ажиллагаатай нь танилцан уг арга хэмжээнд оролцох талаар мэдээлэл өгч ажилласан. Арга хэмжээнд “Дарьт шүтээн” ХХК оролцох болсон бөгөөд тухайн байгууллагын талаар мэдээллийг Аймгийн ХХААГ-т нэгтгэн хүргүүлсэн.
- Монгол улсад орчин цагийн худалдааны салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэх хүрээнд Сүхбаатар аймаг дахь худалдаа эрхлэгчдийн ТББ-тай хамтран “Дурсамж уулзалт” арга хэмжээг 11 дүгээр сарын 12,13-ны өдрүүдэд Баруун-Урт сумын төвд зохион байгуулсан. Уг Хөтөлбөрт арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий комиссыг байгуулж, хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөө гарган нэгдсэн зохион байгуулалтайгаар ажилласан.
- Монгол улсад орчин цагийн худалдааны салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэх хүрээнд “Аймгийн аварга худалдагч” шалгаруулах уралдааныг 11 дүгээр сарын 11-ны өдөр Аймгийн ХХААГ, Стандарт хэмжил зүйн хэлтэстэй хамтран зохион байгуулсан. Уг уралдааны удирдамж, хөтөлбөрийг сумын супермаркет, дэлгүүрүүдээр танилцуулж, Аймгийн хэмжээнд нийт 27 дэлгүүрийн худалдагч нар оролцсоноос 14нь баруун-Урт сумаас хамрагдсан.

Тэмцээний аварга худалдагчаар Номин худалдааны төвийн худалдагч Г.Ариунзаяа шалгарсан.

- Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг нэгтгэж ажилласан.
- Тухайн сарын Өрх болон Аж ахуйн нэгжийн Төмс, хүнсний ногооны үнийн мэдээг Статистикийн хэлтэсрүү хүргүүлсэн.
- Түрээс болон Нөөцийн өвс хүлээн авах, Хурдан саарал хоршоотой өвс худалдан авах гэрээ, Захирамжийг бэлэн болгох ажлыг хийсэн.
- Амгалан хошуун дахь бэлчээрийн гүний худгийг хүлээж авсан.
- Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын А/207 тоот “Мал сүрэгт үзлэг, ангилалт хийх тухай” захирамжийн дагуу Баруун-Урт сумын 6-н өрхийн 2150 малд бүртгэл ээмэгжүүлэлт хийсэн.
- Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын аймаг сумын сайн малчдаас авсан Баяндэлгэрийн улаан ухна, Үзэмжин үүлдрийн хуц зэрэг үүлдэр сайтай малыг ээмэгжүүлэлт хийсэн.
- Малын тоо толгойн татварыг багийн засаг дарга нартай уулзаж татвараас нэхэмжлэл гаргасан.

ДӨРӨВ. ИРГЭДЭД ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ТҮРГЭН ШУУРХАЙ ҮЗҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

Төрийн үйлчилгээний оператораас 10 төрлийн төлбөртэй-12, төлбөргүй-49 нийт-51 лавлагаа үйлчилгээг иргэдэд тус тус гаргаж үйлчилсэн байна.

- Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх лавлагаа-17
- Иргэний үнэмлэхний лавлагаа-6
- Цагдаагийн тодорхойлолт-6
- Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа-5
- Үл хөдлөх хөрөнгийн жагсаалтийн лавлагаа-5
- Оршин суугаа газрын лавлагаа-4
- Жолоочийн үнэмлэх захиалга-4
- Шүүхийн шийдвэр-2
- Жолооны үнэмлэхний лавлагаа-1
- Иргэнд олгох тодорхойлолт-1
- ОНХС-ийн мэдээллүүдийг baruun-urt.su.gov.mn байршуулсан.
- Баннер – 10, Baruun-urt.su.gov.mn – 15 мэдээ, Баруун-Урт сумын ЗДТГ-ын пэйж хуудсанд - 10 мэдээ, Baruun-urt.su.gov.mn -8 мэдээ, Сүхбаатарын өнгө сонин- 5 мэдээ, BBS Телевиз – 3 мэдээ нийтэлсэн.
- Засаг даргын баярын бичиг -14, ИТХ-ын хүндэт өргөмжлөл – 30, Хүндэт иргэн -4 иргэнийг шагнасан.
Тайлант хугацаанд иргэдэд шаардлагатай Багийн Засаг даргын 420 тодорхойлолт гаргасан.
- Зорилтот бүлгийн Азийн хөгжлийн банк, Японы ядуурлыг бууруулах сангийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн хүрээнд Аймгийн нэгдсэн эмнэлэгтэй

- хамтран зорилтот бүлгийн 200 эмэгтэйг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан
- Улаанбаатар хотын "Элгэн сэтгэл" ХХК, ХХҮГ-тай хамтран Баруун-Урт сумын ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сонсголын дижитал аппаратад суулгах ажилд Баруун-Урт сумын 62 иргэнийг хамруулсан.
 - Хөгжлийн бэрхшээлтэй 2 иргэнтэй 1 өрхөд 2 ААН-тэй хамтран хүнс болон ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн хандивласан.
 - Баруун-Урт сумын хамтарсан багт тайлант сард 15 кэйс ирсэнээс нөхцөл байдлын үнэлгээ хийн ажиллаж байна. Нийт-5 кэйсийг хаасан.
 - Багийн ажлын алба эсрэг заалттай болон 3-р тундаа хамрагдаагүй 500 иргэнтэй утсаар холбогдож мэдээллийг хүргэсэн.
 - 5-р багаас ОБГазартай хамтран айл өрхөөр орж 3 дугаар тундаа идэвхтэй хамрагдах талаарх мэдээллийг хүргэж ажиллаж байна.
 - 6 багийн ажлын алба Эрүүл мэндийн яамнаас Ковид -19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор 60-с дээш насны ахмадуудад дархаалуулалтын багцыг эрүүл мэндийн газраар дамжуулан олгосон. Энэхүү ажлын хүрээнд багийн 60-дээш насны 20 ш дархлаажуулалтын витаминь 11 сарын 01-өдрөөс-20 өдрийн хооронд гэрээр нь хүргэн өгч үйлчилсэн.
 - Тайлант сард 19 иргэнийг түр ажлын байранд зуучилсан. Үүнд: Жишиг баг төслийн хүрээнд хашааны дайман хаалга суурилуулах ажилд 17 өрхийг зуучилан хамруулсан.
- Монгол улсын хэмжээнд 5 жил тутам явагддаг ААН, Хувиараа хөдөлмөр эрхлэгчийн ээлжит тооллого 2021 оны 11 сарын 01-25 хооронд явагдаж байна.Өнөөдрийн байдлаар 299 хувиараа хөдөлмөр эрхлэгч тоолоод байна. Ажлын явц-64%
- Монгол улсын хууль “Малын тоо толгойн албан татварын тухай” хуулийн хэрэгжилтийн хүрээнд Аймгийн татварын албанд малчин болон мал бүхий иргэдийн нэрчилсэн судалгааг гарган өгч ажиллалсан. Мөн багийн ажлын алба хуулийн хэрэгжилтийг хангах, ажлыг эрчимжүүлэх зорилгоор иргэд рүү утсаар холбогдож мэдээллийг хүргэн ажиллаж байна.
- 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Гэмт хэрэг зөрчил, учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжын мэдлэгийг нэмэгдүүлэх аяны хүрээнд багийн нутаг дэвсгэр дэх Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны 40 эрэгтэй сурагчдад аймгийн цагдаагийн газрын Хүүхдийн мэргэжилтэн цагдаагийн хошууч Б. Тэгшжаргалтай хамтран Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь сэдэвт сургалтыг зохион байгууллаа.
- Багийн малчин өрхийн боловсрол өргөө дотуур байранд амьдардаг 2 сурагчийг эргэж амьдарч буй орчин нөхцөл байдалтай нь танилцан ажилласан.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор багийн ОН-н цагдаа Э.Даваахүүтэй хамт багийн нутаг дэвсгэр дэх айл өрхөөр орж санал хүсэлтийг сонсон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмж зөвлөгөө өгч ажиллалаа.
- 8,9 Багийн ажлын албанаас санаачлан Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн А.Магадцэцэг, Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Стрессийг зохицуулах нь” сэдэвт сургалтыг зохион байгуулж хүчирхийлэлд өртөж болзошгүй болон зорилтот бүлгийн өрхийн 8 иргэнийг хамруулж сургалт зохион байгууллаа.
- 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Гэмт хэрэг зөрчил, учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжын мэдлэгийг нэмэгдүүлэх аяны хүрээнд багийн нутаг дэвсгэр дэх Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны 30 эмэгтэй сурагчдад аймгийн цагдаагийн газрын Хүүхдийн мэргэжилтэн цагдаагийн хошууч Б. Тэгшжаргал, багийн хэсгийн байцаагч цагдаагийн дэслэгч Э. Батцэнгэл нартай хамтран Өсвөр насны охидыг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

- Зөв боломж төрийн бус байгууллагын уулзалтанд архины хамааралтай 2 иргэнийг хамруулсан.
 - Хэсгийн төлөөлөгч нартай хамтран зорилтот 10-н өрхөөр гэрийн айлчлал, 14-н аж ахуй нэгжид гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, хяналт шалгалт хийж, холбогдох шаардлагыг тавьж ажилласан.
 - Хүнсний эрхийн бичиг авдаг 11 өрхийг хамруулан Уртын голын баруун хэсгийг мөн мандал хорооллын 206, 215-р байрны иргэдээр өөрийн эзэмшлийн газруудыг тус тус цэвэрлүүлээ.
 - Баруун-Урт сумын ХАӨМСангийн баяжилтыг багийн түвшинд тухай бүр өрх, хувь хүний үзүүлэлтийн алдааг шалган засварлаж байна. Тайлант сард өрхийн-30, хувь-хүний үзүүлэлтийн-50 алдаа засварласан байна.
 - Багийн Facebook Page хуудсаар багийн иргэддээ сургалтын зар 3, гэр бүлийн харилцаа сургалт 1, дархлаажуулалтын мэдээлэл 4, цаг үеийн мэдээ мэдээлэл 3 тавьж бусад мэдээлэл, мэдлэгийг тогтмол хүргэн ажиллаж байна.
-
- 6 дугаар багийн иргэн Ц.Очирбат нь тархины хавдар оноштойгоор УБ хотруу эмчилгээнд явахад дэмжлэг болгож 50000₮ өгсөн.
 - Багийн нутаг дэвсгэрт ус ихээр тогтдог 3 байршилд нийт 7 машин шороо асгуулж тэгшлүүлсэн.
 - Иргэнд эрүүл, аюулгүй орчин бий болгох зорилгоор мандал хорооллын 116-р байранд хөршийн холбоо байгуулж ажиллалаа.
 - Мөн тус байрны 15 өрхийг “Уртын Гэгээ” ОНӨҮГ СӨХ-д бүртгүүлээ
 - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Цайрт, Саруул хотхоны 6 байрны гадна зогсоол, ойр орчмыг бүрэн харсан нийт 9 ширхэг камерын ажил хийгдэж дууслаа. Гүйцэтгэгч байгууллагаар Талын технологи ХХК ажиллалаа.
 - -Зэвсэг 2021 арга хэмжээний дагуу багийн буутай 16 иргэнд мэдээлэл хүргэсэн.
-
- 7 дугаар багийн ажлын албанаас 9-р ангийн 10 охиныг Тэвчээр баг шийдэл сургалтанд хамруулсан.
 - Багийн ажлын албаны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд Бага наснаасаа шүдээ хэрхэн хайрлан хамгаалдаг болох, шүдний өвчлөлийн тоог бууруулах зорилготой “Эрүүл шүдний ач тус” сургалтыг АНЭ-ийн шүдний их эмч Б.Наранчимэгтэй хамтран амжилттай зохион байгуулсан. Сургалтыг 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр 8 дугаар цэцэрлэгийн Б.Нандинцэцэг багштай бэлтгэл “В” бүлгийн 25 хүүхдэд зохион байгууллаа.
 - 9 багийн ажлын албанаас санаачлан хүүхдийн тоглох аюулгүй орчинг бүрдүүлэх зорилгоор багийн тоглоомын талбайн хойд болон урд талд “ХҮҮХЭД ТОГЛОЖ БАЙНА” анхааруулах тэмдэгийг байрлууллаа.
 - Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх аяны хүрээнд 8 төрлийн судалгааг боловсруулан гаргалаа. Хэсгийн байцаагч Э. Батцэнгэлд гаргаж өглөө.
 - Архины хэрэглээтэй нийт 71 өрхийн судалгаа
 - 3-р тунгийн вакцинжуулалтын ажилтай холбогдуулан Тагнуулын хэлтэст төрийн албанд ажилладаг иргэдийн вакцинд хамрагдсан эсэх судалгаа
 - Тэргэнцэртэй иргэдийн судалгаа гаргасан.
 - Ахмадын судалгаа гаргасан
 - Багийн эмзэг цэгийн судалгаа
 - Малын хөлийн татвартай холбогдуулан малчин болон мал бүхий иргэдийн судалгаа

➤ Тус сургалтад ИҮТ-ийн 16 албан хаагч сургалтанд хамрагдаж жендерийн талаарх мэдлэг, мэдээллээ дээшлүүлсэн.
➤ Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хандах нийгмийн хандлагыг эерэгээр өөрчлөх тэдэнд тулгарч буй нийгмийн болон орчны саад бэрхшээл ялгаварлан гадуурхалалтыг хэрхэн арилгах тухай ойлголт хандлагын сургалтыг Монголын хараагүйчүүдийн үндэсний холбооны сургагч багш, ХХҮГ-тай хамтран зохион байгуулсан бөгөөд тус сургалтад багийн зохион нар хамрагдсан.
➤ Баруун-Урт сумын ЗДТГазрын дотоод сургалтанд ИҮТ-ийн 6 албан хаагч хамрагдаж мэдлэг, чадвараа дээшлүүлсэн.

ТАВ. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР ЦАР ТАХЛЫН ХҮРЭЭНД ХИЙГДЭЖ БАЙГАА АЖИЛ АРГА ХЭМЖЭЭ

- Коронавируст халдварт өвчний батлагдсан тохиолдлын тусгаарлан эмчлэх байранд ажиллаж байсан 25 эмчийг тусгаарлах /Амгалант дэнж, / байрны халдвар хамгааллын дэглэмийн дагуу бэлдэж, шаардлагатай бэлэн байдлыг байнга ханган ажиллаж байна.
- Тусгаарлан ажиглах байранд орсон иргэдийн хоол ор хоногийн төлбөрийг тооцоолон гаргаж холбогдох албан тушаалтад хүргүүлсэн .
- Вакцинжуулалтын нэмэлт 3- дахь тунгийн нэг цэгийг ажиллуулж мэдээг өдөр бүр гаргаж тайлагнаж байна Бруун-Урт сумын хэмжээнд 18-дээш насны иргэд 3-р тунд 44 % хамрагдаад байна. Хамрагдалтын хувь бага байгаатай холбогдуулан вакцинд хамрагдах иргэдийн судалгааг гарган нэрсийг 9 багт өгч утасаар холбогдон хувийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна.
- "Тамхидалтын эсрэг хувьсгал 2" Кампанит ажлын хүрээнд :
-Нөлөөллийн уулзалтад ААН, төсөвт байгууллагуудыг хамруулж “ХОТ-ТАМХИГҮЙ АЖЛЫН БАЙР ДЭМЖИХ АМЛАЛТ”-ыг тунхаглан, тамхигүй хотын төлөө хамтран ажиллах амлалтад гарын үсэг зурж баталгаажуулсан
-"Тамхидалтын эсрэг хувьсгал 2" төлөвлөгөө боловсруулан төлөвлөгөөний дагуу төсөвт байгууллагуудтай хамтран ажиллаж байна.
- 11-р сарын 10-ны өдөр Баруун-Урт сумын Онцгой комисс, ерөнхий зориулалттай мэргэжлийн ангид гамшгаас хамгаалах команд штабын үзлэг ,сургалт ерөнхий зориулалттай мэргэжлийн ангид байгаа эрүүл мэндийн бүлгийг ахлан бэлтгэл бэлэн байдлыг хангаж оролцлоо .

2021 оны хяналт шинжилгээ үнэлгээний ажлын хэсэг орж ажилласан

- Зөв хэвшил-Зөв амьдрал хөтөлбөрийн хүрээнд иргэдрүү чиглэсэн уриалгын постог гаран ажилласан
- Бэрх биш ээлтэй аяны хүрээнд зохион байгуулсан Бэрхшээл ба тэгш байдал сургалтад хамрагдсан.
- 2020 оны тусгаарлан ажиглах байранд орсон төрийн албан хаагчдын байр, хоолны төлөрийн талаарх асуудлыг Аймгийн Онцгой комиссын 2021 оны 23-р хурлаар оруулсан шийдвэрлүүлсэн.
- Байгууллагын албан хаагчдын 3 дугаар тунд хамрагдалтын судалгааг авч Аймгийн шуурхай штабруу хүргүүлээ.

ЗУРГАА: ТӨСӨВ, ТӨРИЙН САНГИЙН ЧИГЛЭЛЭЭР

Төрийн сан нь төсвийн болон төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог түргэн шуурхай гүйцэтгэх, төсвийн хэрэгжилтийг хангах, урсгал хяналтыг гүйцэтгэхэд гол анхаарлаа хандуулан ажиллаж байна.

11-р сарын байдлаар орон нутгийн болон төвлөрүүлэн захирагчийн харъяа төсөвт байгууллагуудын 14,268,531.2 мянган төгрөгийн /7078/ мөнгөн зарлагын гүйлгээнд хяналт тавин баталгаажуулсан.

Төрийн сангийн хувьд 1,511,901.8 мянга төгрөгийн татварын болон татварын бус орлого орж, татварын орлого төлөвлөгөө нь 109.6 хувьтай байна.

Төрийн сан 18н байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр хянан хүлээн авч, нэгтгэн сумын төсвийн гүйцэтгэлийн өр авлагын мэдээг Freebalanceпрограммд оруулсан.

Төлбөр тооцооны өдөр тутмын ажил гүйлгээний баримтуудыг бүрэн бүрдүүлж, НББ-ийн журналтай тулгаж, тухай бүр төрийн сангийн харилцах, кассын мемориалын баримтуудыг үдэж архивын нэгж үүсгэсэн.

Орон нутгийн хөгжлийн сангийн удирдлага мэдээллийн системийн хуваарилалт, төлөвлөлт, хэрэгжилт цэсэд ОНХС-гийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний мэдээллийг тухай бүр оруулан ажиллаж байна

Сум хөгжүүлэх сангийн хүрээнд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг үйл ажиллагаанд хяналт тавьж, зээлийн хүү болон үндсэн зээлийн төлөлтөд тогтмол хяналт тавин зээлийн төлөлтийн хуваарийг тухай бүр хөтлөн ажиллаж байна. Мөн орон нутгийн BBS телевизтэй хамтарч 2021 онд сум хөгжүүлэх сангаас зээл авсан Б.Хонгорзулыг сумын хөгжил өрхөөс нэвтрүүлэгийн зураг авалтад оруулсан.

OSMI групптэй хамтран байгууллагадаа ISO9001:2015 стандартыг нэвтрүүлэх ажлыг хэсэгт ажиллаж санхүүгийн чиглэлийн баримт бичгийг боловсруулах ажлыг гүйцэтгэж байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Статистикийн мэдээ тайлан гаргалтанд хяналт тавин ажиллаж байна ХАӨМСангийн алдааг өдөр бүр уншуулж, тухай бүр нь баяжилт болон алдааг засуулж багийн ажлын албатай хамтран ажиллаж байна. Мөн ААНэгжийн улсын тооллого 2021 оны 11 сарын 01 нээс сумандаа зохион байгуулж, тооллогонд хамрагдалт 67%-тай байна.

“Зөв хэвшил-Зөв амьдрал” аяны хүрээнд Санхүүгийн албанаас сумын ИТХурлын төлөөлөгч, аймгийн нэгдсэн эмнэлэгийн сэтгэц наркологийн тасгийн эрхлэгч Д.Барцэцэгтэй хамтран “Тамхинд амьсгалах агаараа бүү алд” уулзалт, арга

хэмжээг ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 11 а,в бүлгийн сурагчдын дунд зохион байгуулсан.

Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газар